



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/208

Хэрлэн сум

**Төсөл арга хэмжээний худалдан  
авах ажиллагаа зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дүгээр зүйлийн 60.1.21, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.5, 10.6 дахь хэсэг, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн 2024 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан “Үүрэн холбооны сүлжээ (Хэнтий, Норовлин, Баян- Овоо, Галшар, Мөрөн, Батноров, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адарга, Дэлгэрхаан, Дархан, Баянмөнх, Баянхутаг сум)” төсөл, арга хэмжээг 2 багцад хуваарилан худалдан авах ажиллагааг зохион байгуулсугай.

2.Худалдан авах ажиллагааны багцын төсөвт өртөг, санхүүжих дүнг хавсралтаар баталсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны  
 дугаар сарын 19-ны өдрийн  
 дугаар захирамжийн хавсралт

Багцын дугаар	Багцын нэр	Төсөвт өртөг / төгрөг/	2024 оны санхүүжилт (төгрөг)
Багц 1	Үүрэн холбооны сүлжээ /Хэнтий, Норовлин, Баян-Овоо, Батноров, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адарга, сум/	1,574,838,460.00	472,446,153.84
Багц 2	Үүрэн холбооны сүлжээ /Хэнтий, Галшар, Мөрөн, Дэлгэрхаан, Дархан, Баянмөнх, Баянхутаг сум/	1,349,861,540.00	404,953,846.16
<b>Нийт</b>		<b>2,924,700,000.00</b>	<b>877,400,000.00</b>